ВИДЕО МЭДЭЭ · 2021 оны 8-р сарын 27

ГЭЭГДЭЛ ЭД ХӨРӨНГӨ ЗАВШИХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ



Про подкаст №54

УЕПГ-ын Олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн Ю.Ариунзаяа Орхон аймгийн прокурорын газрын ахлах прокурор Ц.Мөнхтуяатай "Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр ярилцлаа.

- Монгол хэлний тайлбар толинд ЗАВШИХ гэдэг үгийг бусдын юмыг өөрийн болгох, хувьдаа ашиглах, юмыг төдий л бэрхшээлгүйгээр олох гэж тайлбарласан байдаг.

- Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална".

- Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.5 дугаар зүйлд "Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших" гэмт хэргийг хуульчилсан.

Видео: https://www.youtube.com/watch?v=s54JdFVCnQI

- Төлбөр тооцооны алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, эд хөрөнгө, гээгдэл эд

хөрөнгө, алдуул малыг бусдын өмчлөл, эзэмшилд байгааг мэдсээр байж завшсаны улмаас бага хэмжээнээс буюу 300 мянган төгрөгөөс дээш хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 450.000-2.700.000 төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр заасан байдаг.

- Энэ гэмт хэргийг үйлдэж бусдад ноцтой эсхүл их хэмжээний хохирол учруулсан бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

- Гээгдэл эд хөрөнгө олсон этгээд тухайн эд хөрөнгийн өмчлөгч буюу шаардах эрх бүхий этгээдэд нэн даруй мэдэгдэж, хүлээлгэн өгөх үүрэгтэй. Хэрэв тийм этгээд байхгүй бол орон нутгийн захиргааны буюу цагдаагийн байгууллагад мэдэгдэж, тухайн эд хөрөнгийг хадгалж хамгаалах, эсхүл тэдгээр байгууллагад шилжүүлэх үүрэгтэй.

- Харин эрх бүхий байгууллагад мэдэгдсэнээс хойш нэг жилийн дотор өмчлөгч буюу эрх бүхий этгээд нь тогтоогдоогүй бол тухайн эд хөрөнгийг олсон этгээд өмчлөх эрхтэй.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2636